



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 1/199


Зуунмод

Олон нийтийн цагдаагийн ажилтны
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын "Цагдаагийн албаны тухай хууль"-ийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.4.2-ын "а" дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтыг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай зохион байгуулсугай.
2. Олон нийтийн цагдаагийн ажилтнаар судлагдсан иргэдэд сургалт явуулах сургагч багш, шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сургагч багш нарт өгөх үүрэг, чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан үр дүнтэй зохион байгуулж, дүнг 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр танилцуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Доржбалжид/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Наранчимэг/-д даалгасугай.
5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ГАНЗОРИГ

Tushaal

470459

Цагдаагийн газрын даргын 2018 оны
12 дүгээр сарын 10 -ны өдрийн 0199
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ШАЛГАЛТЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН, СУРГАГЧ БАГШ НАРЫН ЖАГСААЛТ**

Комиссын дарга:

-Н.Доржбалжид-Нийтийн хэв журам
хамгаалах тасгийн дарга, цагдаагийн
хошууч

Нарийн бичгийн дарга:

- Э.Ундармаа-Урьдчилан сэргийлэх
ажил хариуцсан мэргэжилтэн,
цагдаагийн дэслэгч.

Гишүүд:

- А.Учрахбаяр-Хэв журмын ажил
хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн
ахмад.

СУРГАГЧ БАГШ НАРЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Алба хаагчийн цол, овог нэр	Албан тушаал	Сургагч багшийн заах хичээлийн төрөл
1	а/д Д.Мөнгөнхүү	Баянчандмань сум дахь Цагдаагийн хэсгийн дарга	Нэг бүрийн тусгай хэрэгсэл, хэт богино долгионы радио, холбоо, холбооны онцлог, техник хэрэгслийн танилцуулга,
2	д/ч Э.Ундармаа	Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн	Олон нийтийн цагдаагийн ажиллах дүрэм, журам

ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

Цагдаагийн газрын даргын 2018 оны
11 дүгээр сарын 10 -ны өдрийн 01/199
тоот хоёрдугаар тушаалын хавсралт

СУРГАГЧ БАГШ НАРТ ӨГӨХ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

1. Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтыг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь чанартай зохион байгуулах.

2. Сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж, бэлтгэл ажлыг сайтар хангаж, заах хичээлийн сэдэвт холбогдох хууль, тогтоомж, онол арга зүйн асуудлыг судалж, хичээлд заах бэлтгэлээ ханга.

-Лекцийн хичээлийг суралцагчдад мэдээлэл өгөх, харилцан мэдээлэл солилцох хэлбэрээр, семинар ярилцлага, дасгалын хичээлийг суралцагчдаар мэдлэг зохиомжлон бүтээлгэх, биечлэн хийлгэх, асуудал шийдвэрлүүлэх /кейс/, суралцагчдын оролцоог хангах зэрэг "Суралцагч төв"-тэй сургалтын аргыг түлхүү хэрэглэн зохион байгуулах.

-Хичээлийн цаг төлөвлөлт, хуваарийг мөрдөж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл таслах, хоцрох, сургалтыг төлөвлөсөн хугацаанаас эрт дуусгах, сургалтад оролцож байгаа иргэдэд дур мэдэн чөлөө өгч, сургалтыг хийдүүлэх боломж олгох зэрэг зөрчил гаргахгүй байх.

3. Сургалтад хамрагдаж буй иргэдэд ирцийн бүртгэлээр хяналт тавьж, сургалтад хамрагдсан байдал, идэвх санаачилга, үр дүнгийн талаар танилцуулах.

4. Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтад шаардагдах зардлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх.

5. Дадлагын сургалтад албаны галт зэвсгээр буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдөх, баталгаа гаргуулан авах, галт зэвсэг сум олгох үеийн тушаалыг гаргаж, хэрэгжилтийг хангах.

6. Албаны болон жагсаалын бэлтгэлийн дүрэм, журмын дагуу явуулах.

7. Сургагч багш нар хичээл заахдаа албаны дүрэмт хувцсыг зохих журмын дагуу зөв хэрэглэж, сургалтын үед харилцааны соёл, ёс зүйн байдлаа онцгой анхаарч, суралцагчдад үлгэр жишээ үзүүлэх.

8. "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм", "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахин биелүүлэх.

9. Сургалтын үр дүнг Цагдаагийн газрын дарга болон Цагдаагийн ерөнхий газрын сургалтын нэгдсэн төвд танилцуулах.

10. Дадлагын сургалтыг удирдах алба хаагч сурталыг удирдах талаар удирдамжид заасан үүргийг биелүүлж, суралцагчдад мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд анхаарч, өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах.

ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР